



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2023/07/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2023 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Ихбаяр Утас: 70593113 Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Оюун-Эрдэнэ Утас: 70593113 Цахим хаяг: Oyun-erdenet@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	6
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	6
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	7
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Материаллаг байдал	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
4.5.1 Завсрын аудитын талаар.....	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
5. Аудитын илрүүлэлт.....	11
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймэг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Үнэмт хаяг: dundgovt@audit.gov.mn

2023.03.25 № 132.

төсвийн _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЛУУС
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ӨЛЗИЙХИШИГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариушаагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 211.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын төсөвт байгууллагууд төсвийн шинэчлэлтэй холбоотой орон нутгийн төсвөөс улсын төсөвт шилжин, 2,034.5 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж холбогдох хууль, журмын дагуу бүртгэл тайланд тусгасан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар нь хууль, тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр урамшуулал олгосон зөрчил нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу тайлагналын эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байлаа.

0012020263

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 хөтөлбөр, 23 зорилт, 150 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 87.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,037,453.4	673,880.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	457,059.4	371,580.8
33	АВЛАГА	263,317.5	155,500.2
35	БАРАА МАТЕРИАЛ	317,076.6	58,399.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	88,400.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,659,081.2	1,008,113.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,659,081.2	1,008,113.3
39200	Биет хөрөнгө	2,522,129.2	877,659.3
39300	Биет бус хөрөнгө	136,952.0	130,454.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,696,534.6	1,681,993.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,246.8	15,903.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,246.8	15,903.0
41300	Өглөг	20,246.8	15,903.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,676,287.8	1,666,090.9
51	Засгийн газрын хувь оролцоо	3,676,287.8	1,666,090.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,306,293.0	479,157.2
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,306,293.0	479,157.2
51200	Хуримтлагдсан үр дүн	1,471,231.6	776,595.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	898,763.2	410,337.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,696,534.6	1,681,993.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,473,265.4	1,040,425.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	62,359.6	196,402.0
110	Орлогын албан татвар	18,195.4	128,053.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	18,195.4	128,053.6
113	Хөрөнгийн албан татвар	39,663.6	63,597.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,500.6	4,751.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	582,145.5	202,904.4
120	Нийтлэг татварын бус орлого	582,145.5	202,904.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,828,760.2	641,118.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,232,230.6	819,786.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,232,230.6	819,786.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,444,726.4	562,759.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,105,330.6	228,666.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,314.0	28,376.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	149,035.0	26,029.8
2104	Хангамж, бараа материалын зардал	96,908.3	57,472.3
2105	Нормативт зардал	252,492.0	50.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	83,201.2	6,450.0
2107	Томилолт, зочны зардал	5,474.0	3,948.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,520.8	25,858.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	580,450.5	185,907.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	787,504.2	257,026.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	241,034.8	220,639.0

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	25,735.4	2,062,468.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	215,299.4	-1,841,829.1

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,465,688.4	3,465,688.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,700.0	-4,700.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,460,988.4	3,460,988.4
9	Тайлант үеийн үр дүн	215,299.4	215,299.4
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,676,287.8	3,676,287.8
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,676,287.8	3,676,287.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-168,367.9	-168,367.9
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,507,919.9	3,507,919.9
19	Тайлант үеийн үр дүн	-1,841,829.1	-1,841,829.1
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,666,090.9	1,666,090.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,919,863.2	988,103.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	62,359.6	196,402.0
110	Орлогын албан татвар	18,195.4	128,053.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	18,195.4	128,053.6
113	Хөрөнгийн албан татвар	39,663.6	63,597.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,500.6	4,751.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,020.4	2,165.9
1181	Газрын төлбөр	1,480.2	2,585.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	186,743.3	153,057.0
120	Нийтлэг татварын бус орлого	186,743.3	153,057.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,670,760.2	638,644.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,698,731.8	657,822.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,698,731.8	657,822.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,909,698.6	609,468.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,104,311.2	272,639.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	145,367.3	33,310.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,861.4	163,473.2
2104	Хангамж, бараа материалын зардал	72,365.2	28,283.1
2105	Нормативт зардал	177,431.8	200.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,702.0	40,249.8
2107	Томилот, зочны зардал	5,474.0	3,948.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,790.2	26,773.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,395.4	40,590.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	789,033.2	48,354.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	221,131.3	330,281.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	54,485.1	305,759.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,485.1	305,759.7
2200	Дотоод эх үүсвэрээр	54,485.1	305,759.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-54,485.1	-305,759.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-110,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	110,000.0

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	166,646.2	-85,478.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	290,413.2	457,059.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	457,059.4	371,580.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,371,952.8	1,014,833.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	692,326.0	607,553.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	665,809.5	581,058.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	278,985.1	272,639.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,910.1	33,310.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	166,236.7	161,901.9
2104	Хангамж, бараа материалын зардал	22,915.9	22,726.3
2105	Нормативт зардал	200.0	200.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,155.7	38,116.5
2107	Томилолт, зочны зардал	4,153.0	3,948.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,215.9	11,144.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,037.1	37,070.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,516.5	26,495.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	519,261.1	297,280.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	160,365.7	110,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,371,952.8	926,556.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	162,594.2	162,594.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	713,495.8	658,256.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	495,862.8	105,705.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	407,945.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	303,882.2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,041.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,041.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,889.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,571.3
2104	Хангамж, бараа материалын зардал	5,578.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,133.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,607.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,151.2
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,151.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43,032.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,032.6
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-8.5
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Луус сумын Засаг дарга нь төрийн үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг, аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тухайн байгууллага эрхэм зорилгоо “Төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх, гаргасан шийдвэрийнх нь биелэлтийг

хангуулах, иргэдэд төрийн чанартай үйлчилгээг хүргэж тасралтгүй сурталчлах алба байхад оршино” гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжид өөрчлөлт орсон нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй, дотоод аудитыг ТЕЗ-ийн харьяа Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хэрэгжүүлсэн байна. Тайлант онд Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод хяналтаас санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж 4 зөвлөмжийг хүргүүлжээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон байна. Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, орон нутгийн төсвөөс санхүүждэг байсан Соёлын төвүүд харьяалагдах яамдаасаа санхүүжилтээ авч, санхүүгийн тайлангаа яамдад нэгтгүүлдэг болсон. Нэгтгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой 2022 оны байгууллагуудын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчид шилжүүлэн өгсөн байна. Дээрх байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан байна.

3.4.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,014,540.7 мянган төгрөгөөр буюу 54.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт №1
Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөг/

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	457,059.3	371,580.8	(85,478.5)
Авлага	263,317.5	155,500.2	(107,817.3)
Бараа материал	317,076.6	146,799.6	(170,277.0)
Үндсэн хөрөнгө	2,659,081.2	1,008,113.3	(1,650,967.9)
Нийт хөрөнгө	3,696,534.6	1,681,993.9	(2,014,540.7)
Өр төлбөр	20,246.8	15,903.0	(4,343.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,676,287.8	1,666,090.9	(2,010,196.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,696,534.6	1,681,993.9	(2,014,540.7)

Дээрх хүснэгтээс харахад санхүүгийн байдлын үзүүлэлтүүд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан нь улсын төсвийн байгууллагуудын эхний үлдэгдлийг холбогдох яамд руу нь шилжүүлэх бичилт хийж, тайлант үеийн болон өмнөх үеийн үр дүнг бууруулсантай холбоотой байна. Үүнд эргэлтийн хөрөнгө 363,572.8 мянган төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 1,650,967.9 мянган төгрөг, цэвэр өмч хөрөнгө 2,010,196.9 мянган төгрөгөөр тус тус буурчээ.

3.4.2 Орлого бүрдүүлэлт

Луус сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай 43 дугаар тогтоолоор тайлант онд 244,477.9 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 243,753.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 99.7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого /ИОТГХ/	22,800.0	22,256.7	(543.3)	97.6
Хадгаламжийн хүүгийн орлого	36,300.0	26,554.7	(9,745.3)	73.2
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого		1,160.0	1,160.0	-
Бууны албан татвар	1,500.0	1,406.0	(94.0)	93.7
Улсын тэмдэгтийн хураамж	2,850.0	396.1	(2,453.9)	13.9
Хог хаягдлын үйлчилгээ	2,500.0	1,769.8	(730.2)	70.8
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	200.0	-	(200.0)	-
Газрын төлбөр	5,300.0	2,585.1	(2,714.9)	48.8
Малын тоо толгойн албан татвар	69,657.9	57,814.8	(11,843.1)	83.0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	2,700.0	4,376.7	1,676.7	162.1
Цалин хөлс болон түүнтэй адилгах орлогоос суутгасан албан татвар	85,900.0	104,636.9	18,736.9	121.8
Татварын орлого	229,707.9	222,956.7	(6,751.2)	97.1
Хүү торгууль	11,870.0	20,796.5	8,926.5	175.2
Бусад орлого	2,900.0	-	(2,900.0)	-
Татварын бус орлого	14,770.0	20,796.5	6,026.5	140.8
Нийт орлогын дүн	244,477.9	243,753.2	(724.7)	99.7

Дараах нэр төрлийн орлого материаллаг дүнгээр тасарсан байна. Үүнд:

- Хадгаламжийн хүүгийн орлого 9,745.3 мянган төгрөгөөр тасарсан нь тус онд иргэдийн арилжааны банк дахь хадгаламж буурсан,
- Малын тоо толгойн албан татвар 11,843.1 мянган төгрөгөөр тасарсан нь өвөлжилт хүндэрч, отор нүүдэл ихэссэнтэй холбоотой малын тоо толгойн татвараа малчид хуулийн хугацаанд төлөөгүйтэй холбоотой тасарчээ.

Дараах орлогууд материаллаг дүнгээр давж биелсэн байна. Үүнд:

- Хүү, торгуулийн орлого 8,926.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь тус сумын нутаг дэвсгэрээр дайрч явдаг хот хоорондын тээврийн хэрэгсэлд цагдаагийн үзлэг, хяналт шалгалт хийж алдаа, зөрчлийг арилгуулах торгуулийг тавьж, барагдуулсантай,

- Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татвар 18,736.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь тухайн жилийн төлөвлөгөөг өмнөх жилээс бууруулан баталсан, төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Луус сумын ИТХ-ын 2021 оны 30 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,484,271.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,484,271.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Луус сумын ИТХ-ын 2022 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт тодотгол хийж, сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,371,952.8 мянган төгрөг, нийт зарлагыг 1,371,952.8 мянган төгрөг болгон бууруулж, баталсан байна. Хасах тодотгол нь улсын төсвийн байгууллагуудын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 5 дугаар сараас эхлэн улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой цалингийн зардлыг хассан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1,371,952.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 692,326.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 519,261.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 160,365.7 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 162,594.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 713,495.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 495,862.8 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 162,594.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 676,771.1 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 105,705.8 мянган төгрөг, нийт 945,071.1 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 68,173.6 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 5,553.6 мянган төгрөгөөр давуулж, туслах үйл ажиллагааны орлого 37,532.2 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 6,814.3 мянган төгрөгөөр тасалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,014,833.6 мянган төгрөг буюу 74.0 хувьтай байгаа нь урсгал зардлыг 84,777.4 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 221,981.1 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээлийг 50,365.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 42,821.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас 27,128.3 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 850.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15,054.3 мянган төгрөг, урьд оны эхний үлдэгдлээс 8.5 мянган төгрөг, нийт 43,041.1 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна. Үүнээс хангамж, бараа материалын зардалд 5,578.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 5,133.0 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1,571.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 20,607.6 мянга, бараа үйлчилгээний зардал 4,000.0 мянга, нийт 36,889.9 мянган төгрөгийг

зарцуулсан байна. Үлдэгдэл 6,142.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 8.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дүгээр сарын 03-ны өдрийн 01/58 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангаас нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 1,681,993.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 16,819.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11,774.0 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланг түүвэрлэн шалгахад тус сумын Засаг даргын Тамгын газар нь төсвөөс хууль, тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр урамшуулал олгосон зөрчил илэрснийг нөхөн төлүүлэх төлбөрийн актыг тогтоосон. Харин дээрх хуулийн хүрээнд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 4,334.8 мянга, бараа, үйлчилгээний бусад зардлаас 70,966.2 мянган төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Луус сумын Засаг дарга нь 2022 онд нийт 8 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан байна.

Мөн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг шалгахад зөрчил илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Луус сумын төсвийн байгууллагуудын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын бараа материалын зарцуулалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

5. Аудитын илрүүлэлт

5.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Луус сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 127,701.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 71,868.6 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 832.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчлийг арилгах албан шаардлага, 55,000.0 мянган төгрөгийн 1 заалт бүхий зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 43.7 хувийг залруулагдаагүй, 56.3 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засаг даргын Тамгын газар	2	31,074.0			2	31,074.0						
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	8,794.6			1	8,794.6						
3	Тусгай зориулалтын сан	1	2,000.0	1	2,000.0								
4	Хоршоо хөгжүүлэх сан	-	-										
5	Орон нутгийн хөгжлийн	1	30,000.0			1	30,000.0						
6	Нэгтгэсэн санхүүгийн тайлан	-	-										
		-	-										
	Дүн	5	71,868.6	1	2,000.0	4	69,868.6	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засаг даргын Тамгын газар	1	-			1.0	-						
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	0	-										
3	Тусгай зориулалтын сан	0	-										
4	Хоршоо хөгжүүлэх сан	0	-										
5	Орон нутгийн хөгжлийн	0	-										
6	Нэгтгэсэн санхүүгийн тайлан	0	-										
	Нийт зөрчлийн дүн	1	-	-	-	1.0	-	-	-	-	-	-	-

Дундговь аймгийн Луус сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
2. Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Засаг даргын Тамгын газар	1	832.9	1	832.9				
Орон нутгийн хөгжлийн сан	1	55,000.0					1	55,000.0
Дүн	2	55,832.9	1	832.9	-	-	1	55,000.0
Нийт дүн	2	55,832.9	1	832.9	-	-	1	55,000.0